


ЦАХИМ ШУУДАНД

УРАН БҮТЭЭЛЧИД ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДАЖ БАЙНА



Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын бие бүрэлдэхүүн, уран бүтээлчид мэргэжлийн болон хууль эрх зүйн цахим сургалтуудад хамрагдаж байна. Хэдийгээр бид цар тахлын улмаас хөл хорио, гэртээ байхыг илүүд үзэж байгаа ч чуулгын удирдлагаас уран бүтээлчдийн мэргэжлийн онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, бэлтгэл сургуулалтын тасралтгүй байдлыг хангаж, уран бүтээлч, ажилтан албан хаагчдаа гэртээ хөгжих нөхцөл бололцоог хангах үүднээс Монголын мэргэжлийн урлагийн их дээд сургуулийн багш нар, нэрт уран бүтээлчдээс ийнхүү мэргэжлийн онолын сургалт, хэсэгчилсэн цахим сургуулалтуудыг авч байгаа нь ихээхэн үр өгөөжтэй ажил боллоо. Тухайлбал, Монголын нэрт удирдаач, Урлагийн гавьяат зүтгэлтэн Н.Туулайхүү "Удирдаач, хөгжимчдийн уран бүтээл дээр ажиллах үеийн харилцаа, амьсгаа хөгжимчдийн ур чадварт нөлөөлөх

нь, СУИС-ийн багш Г.Төвшинтөр "Орчин цагийн Монгол үндэсний хөгжмийн чиг хандлага", докторант М.Мөнгөнцэцэг "Уламжлалт бие биелгээний намбууд", ҮБХИС-ийн багш Ч.Наранхүү "Үлээвэр хөгжмөөр мэргэшихийн онцлог" зэрэг сэдвүүдээр уран бүтээлчдэд онолын цахим сургалт орсноос гадна чуулгын уран сайхны удирдагч, ерөнхий хормейстр, ерөнхий балетмейстр, багш нар уран бүтээлчидтэй сонгодог бүжгийн дасгал, орчин үеийн бүжгийн техник, гоцлол болон цөөхүүл дуучидтай цахим бэлтгэл сургуулалтыг хийж байна. Цахим сургалт үргэлжилж байна.

Д.ГҮНЖИЛМАА

ТӨРИЙН БОЛОН САЛБАРЫН ОДОН МЕДАЛЬ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Цэргийн гавьяаны улаан тугийн болон байлдааны гавьяаны одонт хурандаа генерал Ж.Ёндогийн нэрэмжит Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 анги аранзал улаан тугаа, төрийн торгон цэргээр хамгаалуулан, ёслол төгөлдөр залж, ахмад дайчид, бие бүрэлдэхүүний төлөөллийг оролцуулан төрийн болон салбарын одон медаль гардуулах ёслолын ажиллагааг 5 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Ёслолын ажиллагааны үеэр ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр, ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл хурандаа Ч.Баярсайхан нар хүрэлцэн ирсэн

ахмад дайчид болон бие бүрэлдэхүүнд баяр хүргэж үг хэлсэн юм. Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн түүхийг хамтдаа бүтээлцэж, эх орноо батлан хамгаалах, төрийн ёслол хүндэтгэл, харуул хамгаалалтын хариуцлагатай, хүндтэй албанд мэдлэг боловсрол, оюун ухаан, сэтгэл зүтгэлээ харамгүй хайрлаж, эх орон, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнч зүтгэсэн бид бүхний хөдөлмөрийг төр засаг өндрөөр үнэлж, цэргийн гавьяаны одон, цэргийн хүндэт медаль, хөдөлмөрийн хүндэт медаль, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, "Дайчин алдар-III" медаль, "Эх орны төлөө-II", "Эх орны төлөө-III" хүндэт тэмдэг, ЗХЖШ-ын даргын "Жуух бичиг"-ээр энгэрийг нь мялаасан баярт үйл явдал болж өндөрлөлөө.

ЦАХИМ СУРГАЛТЫН ПРОГРАММЫГ АМЖИЛТТАЙ НӨВТРҮҮЛЖ БАЙНА

Хэрхэн цэргийн мэргэжлийн суурь хичээлийг судлах вэ?

Та Ангийн групп байршуулсан линкүүр орно

Хүсэлт амжилттай илгээгдсэн дараа та энэ хэсгээс гарах шаардлагатай

Хэрхэн дахин дахин хүсэлт илгээх хэсэг гарч ирэх төлөлдөг. Сургалтын албана 8855943 дугаар мэдэгдээрэй

Сургалтын албанаас таны хүсэлтийг хараад бүртгэж идэвхжүүлэх эрх үүсгэнэ.

Сургалтын албанаас таны хүсэлтийг хараад бүртгэж идэвхжүүлэх эрх үүсгэнэ.

ОЙЛГОМГУЙ, АСУУХ ҮНЭС БАЙВАЛ 8855943 ДУГААРТ ХОЛБОГДОРОЙ

Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Ангийн Сургалт, соёл хүмүүжлийн алба 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ковид 19 цар тахлын энэ хүнд цаг үед хангах зорилгоор орчин үеийн цахим платформийг ашиглан ангийн бие бүрэлдэхүүнийг цахимаар хичээлээ үзэх, судлах боломжийг олгож байна. Цахим сургалтын программыг ашигласнаар цаг хугацааг хэмнэж хэзээ ч хаанаас ч бие бүрэлдэхүүнээс судалгаа авах, google drive-д хичээлүүд байршуулж бие бүрэлдэхүүн гэрээсээ онлайнар хичээлээ судлах, google form-ыг ашиглан бие бүрэлдэхүүнээс төрөл бүрийн тест, судалгаа хичээлийн шалгалтуудыг цаг алдалгүй амжилттай авах зэрэг маш олон дэвшилтэй давуу талуудыг бий болгож байна. Мөн нэмэлтээр офицерын судлах 51 хичээл, ахлагчийн судлах 45 хичээлийг тус тус google drive-д байршуулан ангийн сургалт бэлтгэлийг маш үр дүнтэй ахиц дэвшилтэй явуулж байна.

АЛБАА НЭР ТӨРТЭЙ ХААГААД НУТАГТАА ИРЛЭЭ



Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

ЗХЖШ-ын даргын тушаалаар 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар Хилийн цэргийн 0132 дугаар ангид Сүхбаатар аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан цэргүүд халагдаж ирлээ. Ковид 19 цар тахлын халдвараас шалтгаалан хугацаат цэргийн албан хаагчдыг Аймгийн цэргийн штабын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Хошууч Ө.Баясгалан, дайчилгааны офицер дэд хурандаа Б.Батбаатар, орон нутгийн хамгаалалт сургалтын офицер ахлах дэслэгч Т.Сугаржав нар Сүхбаатар аймгаас 15 км-т байрлах Цайрт минерал ХХК-н байранд хүлээн авч түргэвчилсэн оношуураар шинжилгээ авч вакцинжуулалтад хамруулж сум орон нутгийн удирдлага багын дарга нарт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулав.

ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБА ХААХ ХУГАЦАА ДУУСАЖ БЭЛТГЭЛЭЭР ХАЛАГДСАН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАА ХҮЛЭЭЖ АВЛАА




Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын цэргийн штаб

ЗХЖШ-ын даргын тушаалаар 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар хилийн 0245 дугаар ангид Хөвсгөл аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан цэргүүд халагдаж ирлээ. Улс орон даяар коронавируст "Ковид-19" халдвараас шалтгаалан алба хаагчдыг аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа С.Батхуяг болон бусад бие, Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар Мөрөн сумын Дэлгэр мөрөн голын Хилэнтийн гүүрний хяналтын цэг дээр тосон авч сум, орон нутгийн удирдлагуудад нь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбат, Засаг даргын орлогч

М.Хуягбаатар нар Увсын цэнхэр хязгаар болох Монгол Улсын баатар Бэгзийн Гивааны нэрэмжит Хилийн 0245 дугаар ангид Эх орныхоо төлөө хуулиар хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, Монгол Улсынхаа дархан хилийг сахин хамгаалах, хариуцлагатай бөгөөд нэр төртэй үүргийг амжилттай гүйцэтгэж, бэлтгэлээр халагдаж байгаа Хоймор нутгийн эрхлэг хөвгүүддээ чин сэтгэлийн мэндчилгээг өргөн дэвшүүлж, хил зөрчигч нарыг илрүүлсэн цэргийн алба хаагчдыг "Засаг даргын жуух", "Баярын бичиг"-ээр шагнаж урамшууллаа. Мөн Энэ үеэр аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн бэлтгэлээр халагдсан цэргийн алба хаагчдад орон нутагт нээлттэй зарлагдсан ажлын байранд урих, зуучлах талаар мэдээлэл сурталчилгааны ажил хийлээ.

БАЙЛДАГЧИД АР ГЭРИЙНХЭНТЭЙГЭЭ УТСААР ЯРИВ



Зэвсэгт хүчний 120 анги

Өнгөрсөн амралтын өдрүүдэд ангийн хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэртэй нь утсаар яриулах, ялалтын баярын парад үзүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу явууллаа.

ДЭЛХИЙ ДАХИНД

ӨСВӨР НАСНЫХАНД ВАКЦИН ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛОО

АНУ Pfizer вакциныг өсвөр насныханд хийх зөвшөөрөл олголоо АНУ-ын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүнс, эмийн удирдах газар (FDA) 12-15 насныханд BioNTech, Pfizer-ийн хамтран боловсруулсан Ковид-19-ийн эсрэг вакцин хийх зөвшөөрөл олголоо гэж даваа гарагт мэдэгдлээ. "Хүнс, эмийн удирдах газар өнөөдөр коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Pfizer болон BioNTech-ээс яаралтай горимоор 12-15 насны

өсвөр насныханд хийх зөвшөөрөл олголоо. Ингэснээр 2020 оны арванхоёрдугаар сарын 11-нд гаргасан 16 ба түүнээс дээш насныхныг уг вакцинд хамруулах тухай зөвшөөрөлдөө нэмэлт өөрчлөлт оруулж, насны хязгаарыг сунгалаа" гэж тус байгууллагаас мэдээлсэн байна. Хүнс, эмийн удирдах газраас өсвөр насныхныг вакцинд хамруулах боломжтой болсноор цар тахлын эсрэг тэмцэхэд чухал алхам болно гэж үзжээ.

Эх сурвалж: ВВС